



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.2, 6.3.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон мэргэшлийн түвшнээ ахиулах хүсэлтэй иргэнийг ажил олгогчийн захиалгаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй мэргэжлээр ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэлт, тогтвортой ажлын байрыг дэмжихэд чиглэсэн “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн удирдамжийг нийгмийн түншлэлийн байгууллагуудын саналыг тусган боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулан хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Дамбий)-т даалгасугай.

3. “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, тогтмол тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (Б.Батбаатар)-д үүрэг болгосугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД



Т.АЮУРСАЙХАН



ЭРЭЛТЭД НИЙЦСЭН УР ЧАДВАР ОЛГОХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

- 1.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, хувь хүний хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Зорилт

- 2.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:
 - 2.1.1. Ажилгүй, ажил хайж байгаа, ажил олоход хүндрэлтэй болон мэргэшлийн түвшнээ ахиулах хүсэлтэй иргэнийг мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулж, эзэмшсэн ур чадварыг нь үнэлж баталгаажуулах;
 - 2.1.2. Албан бус сургалт, амьдралын туршлагаар олж авсан мэргэжлийн ур чадвараа үнэлүүлэх хүсэлтэй иргэнийг чадамжийн үнэлгээнд хамруулж, гэрчилгээжүүлэх;
 - 2.1.3. Хөтөлбөрт хамрагдсан ажилгүй иргэнийг ажилд зуучилж, ажилтай, орлоготой болоход дэмжлэг үзүүлэх.

Гурав. Хамрах хүрээ

- 3.1. Хөтөлбөрт дараах иргэнийг хамруулна:
 - 3.1.1. Ажилгүй иргэн;¹
 - 3.1.2. Ажил хайгч иргэн;²
 - 3.1.3. Ажил олоход хүндрэлтэй иргэн;³
 - 3.1.4. Мэргэшлийн түвшнээ ахиулах хүсэлтэй иргэн;⁴
 - 3.1.5. Өмнөх мэдлэг, ур чадвараа үнэлүүлэх иргэн⁵.


¹Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.2. "ажилгүй иргэн" гэж ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэнийг;

²Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.1. "ажил хайгч" гэж ажилгүй, ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн болон хандсан иргэнийг;

³Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7. "ажил олоход хүндрэлтэй иргэн" гэж хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн, хорих ангиас суллагдсан болон хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг;

⁴Ажил олгогчийн захиалга, хувь хүний хэрэгцээнд үндэслэн ажилтай иргэнийг мэргэшүүлэх сургалтад хамруулж, мэргэшлийн түвшинг ахиулах;

⁵Өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ (RPL) нь иргэний албан бус сургалт болон ажлын туршлагаар олж авсан ур чадварыг стандартын дагуу үнэлдэг. Хувь хүн болон ажилтан мэдлэг, ур чадвараа нотолж, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээтэй болсноор хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг.



3.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажиллах хүчний хэрэгцээнд суурилан мэргэжлийн ур чадвар олгох сургалтыг дараах салбарын хүрээнд зохион байгуулна:

- 3.2.1. Хүнсний үйлдвэрлэлийн салбар;
- 3.2.2. Хөдөө аж ахуйн салбар;
- 3.2.3. Хөнгөн үйлдвэрийн салбар;
- 3.2.4. Барилгын салбар;
- 3.2.5. Уул уурхайн салбар;
- 3.2.6. Эрчим хүчний салбар;
- 3.2.7. Зам, тээврийн салбар;
- 3.2.8. Мэдээллийн технологийн салбар;
- 3.2.9. Байгаль орчин, аялал жуулчлалын салбар;
- 3.2.10. Үйлчилгээний салбар.

Дөрөв. Хэрэгжүүлэх зарчим

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд доор дурдсан зарчмыг баримтална:

- 4.1.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага болон иргэний хөдөлмөр эрхлэх хэрэгцээг уялдуулсан байх;
- 4.1.2. Засгийн газраас хэрэгжүүлж буй бусад төсөл, хөтөлбөрөөс онцлог, шинэлэг байх;
- 4.1.3. Олон талын оролцоог хангасан, нийгмийн түншлэлд суурилсан, оролцогчдын үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан байх;
- 4.1.4. Хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлт, тэдгээрийг хэмжих арга хэрэгсэл тодорхой байх;
- 4.1.5. Хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэхдээ нөлөөллийн үнэлгээний дэвшилтэт аргачлалыг ашиглах;
- 4.1.6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авлигаас ангид ажиллах, авлигаас урьдчилан сэргийлэх;⁶
- 4.1.7. Хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах үйл явц ил тод, нээлттэй байх;
- 4.1.8. Хөтөлбөр дууссаны дараа хөдөлмөрийн зах зээлийг дэмжих идэвхтэй хөтөлбөр болгон хэрэгжүүлэхүйц байх.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

- 5.1. Хөтөлбөрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам удирдлага, арга зүйгээр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (цаашид "Институт" гэх) нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллана.
- 5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж болон холбогдох үйл ажиллагааны төсвийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам батална. Удирдамжид арга хэмжээний нарийвчилсан зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд тавигдах шалгуур үзүүлэлт, арга хэмжээний үр дүн, оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтыг тусгана.

⁶ Олон улсын Сэргээн босголт, хөгжлийн банк, Олон улсын Хөгжлийн ассоциацийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилттэй төслүүдэд баримтлах "Залилан, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох удирдамж" нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч бүх талуудад хамаатай болно.



- 5.3. Институт чадамжид суурилсан сургалт зохион байгуулах байгууллагыг холбогдох журам болон удирдамжид заасан шаардлагын дагуу сонгон шалгаруулж, үр дүнд суурилсан санхүүжилтийн гэрээ байгуулна.
- 5.4. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хөтөлбөрийн 3.1-т заасан иргэнийг бүртгэх, хамрагдах нөхцөлийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үзүүлнэ.
- 5.5. Хөтөлбөрийг “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн санхүүжилт нь оролцогч байгууллагуудыг чадавхжуулах, сонгогдсон мэргэжлийн ажил, мэргэжлийн стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, мэргэжлийн ур чадвар олгох сургалт зохион байгуулах, ажлын байран дээр дадлагажуулах, иргэний өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ, төгсөлтийн үнэлгээг тус тус зохион байгуулах, чадамжийн гэрчилгээ олгох, хөтөлбөрт хамрагдсан иргэнд хоол, унаа, байрны хөнгөлөлт үзүүлэх болон үйл ажиллагааны бусад зардлаас бүрдэнэ.
- 5.6. Институт хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” хэрэгжүүлэх нэгжид улирал тутам хүргүүлнэ. Тайланд хамрагдсан иргэний мэдээлэл, арга хэмжээний үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгана.

Зургаа. Хэрэгжүүлэх арга хэмжээ

- 6.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:
 - 6.1.1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн мэргэжлийн холбоод (зөвлөл)-ын санал, зөвлөмжид үндэслэн сургалтаар олгох мэргэжлийн чиглэлийг тодорхойлох;
 - 6.1.2. Сургалт зохион байгуулах мэргэжлийн стандарт, чадамжид суурилсан сургалтын агуулга, хөтөлбөрийг сайжруулах, шинэчлэн боловсруулах арга хэмжээг зохион байгуулж, сургагч багш, оролцогч байгууллагыг чадавхжуулж, зөвлөгөө арга зүйгээр хангах;
 - 6.1.3. Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрт тусгах зөөлөн ур чадвар олгох сургалтын жишиг хөтөлбөрийг Институт батлах;
 - 6.1.4. Ажилгүй, ажил хайж байгаа, ажил олоход хүндрэлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадвар, мэргэжлийн ур чадвар олгох онол, дадлагын сургалтад хамруулж, ажлын байранд дадлагажуулах;
 - 6.1.5. Ажил олгогчийн захиалга, хувь хүний хэрэгцээнд үндэслэн ажилтай иргэнийг мэргэшүүлэх сургалтад хамруулж, мэргэшлийн түвшинг ахиулах;
 - 6.1.6. Чадамжид суурилсан сургалтын үргэлжлэх хугацаа 10 хүртэл долоо хоног байх ба 7 хоногт 30-аас доошгүй цагийн хөтөлбөртэй байх;
 - 6.1.7. Сургалтын онол, дадлагын харьцаа 20:80 хувь байх ба дадлагын сургалтын 30-аас доошгүй хувийг тухайн мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр, аж ахуйн нэгж дээр зохион байгуулах;
 - 6.1.8. Сургалтад хамрагдсан иргэний сургалтаар эзэмшсэн ур чадварыг үнэлж, чадамжийн гэрчилгээ олгох;

- 6.1.9. Хөтөлбөрт хамрагдах иргэнд ногдох сургалтын зардлын жишиг хэмжээг мэргэжлийн сургалтын өөрийн өртөгт суурилан тогтоох;
- 6.1.10. Сургалт болон дадлагын хугацаанд олгох хоол, унаа, байрны хөнгөлөлтийг сургалтын ирц, оролцоонд үндэслэн олгох;
- 6.1.11. Албан бус сургалт, амьдралын туршлагаар олж авсан мэргэжлийн ур чадвараа үнэлүүлэх хүсэлтэй иргэнийг холбогдох журмын дагуу чадамжийн үнэлгээнд хамруулж, гэрчилгээжүүлэх;
- 6.1.12. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, мэргэжлийн холбоод (зөвлөл), сургалтын байгууллага, үйлдвэр аж ахуйн нэгж хөтөлбөрт хамрагдсан ажилгүй иргэнийг ажилд зуучлах, тогтвортой ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

- 7.1. Хөтөлбөрийн үр дүн, нөлөөллийг үнэлэхэд дараах шалгуур үзүүлэлтийг ашиглах бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нарийвчлан гаргана:

| № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин |
|---|--|-----------------|
| 1 | Мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан иргэний тоо | 1000 |
| 2 | Сургалтад хамрагдсан иргэдээс чадамжийн гэрчилгээ авсан иргэдийн эзлэх хувь | 80% |
| 3 | Өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах үнэлгээнд хамрагдаж, чадамжийн гэрчилгээтэй болсон иргэний тоо | 200 |
| 4 | Хөтөлбөрт хамрагдсан ажилгүй иргэдээс 6 сарын дотор ажлын байртай болсон иргэдийн эзлэх хувь | 70% |

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

- 8.1. Институт хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд улирал тутам хүргүүлэх бөгөөд тайланд зардлын тайлан, мэдээг хавсаргана.
- 8.2. Хөтөлбөрийн нөлөөллийн үнэлгээг төслийн олон улсын болон үндэсний зөвлөхүүд хамтран зохион байгуулна.
- 8.3. Институт нөлөөллийн үнэлгээ болон бусад тайлан дүгнэлтэд үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зөвлөмж хүргүүлнэ.